



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1/98

Шивээговь сум

Сумын баяр наадмын зардалд  
 хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2023 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Баяр наадам”-ын шууд худалдан авалтыг хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Д.Өлзийсүрэн

(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Л.Цэнд-Аюуш

(Сан хариуцсан нягтлан бодогч)

Б.Энхцэцэг

(Нярав)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Сумын баяр наадамд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийн төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Баяр наадамд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.


4. Үндэсний их баяр наадамд зарцуулагдах төсөвт хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П. ГАНЧИМЭГ



238

Сумын Засаг даргын 2023 оны  
06-р сарын 20-ны өдрийн 4798  
дугаар захирамжийн хавсралт



### БАЯР НААДАМД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Товч утга	Тоо ширхэг	Нэгж бүрийн үнэ	Нийт
1	Соёлын төвийн хөгжмийн засварын үнэ	1	1,110,000	1,110,000
2	Баяр наадмын баннер хэвлэл	1	1,232,000	1,232,000
3	Хэвийн боов	110	4,500	495,000
4	Суурь еэвэн	2	20,000	40,000
5	Цагаан, идээ	9.8	25,000	245,000
6	Ус, ундаа	173	2,500	432,500
7	Чихэр	5	25,000	125,000
8	Жимс, самар, хатаасан жимс	13	15,000	195,000
9	Хиам, огурцы		10,450	125,500
8	Айраг	100	10,000	1,000,000
Нийт				5,000,000